# ОЮУНЛАГ ИРЭЭДҮЙГ ХАМТДАА БҮТЭЭЦГЭЭЕ уриатай “СЭТГЭХ ЧАДВАР-2025” уламжлалт онлайн VI уралдаан

Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургууль, сургуулийн боловсролын багш, удирдах ажилтнууд, Боловсролын газрын дарга, мэргэжилтэн хамрагдана.

2025 оны 05 сарын 24 /Бямба гариг/ 11.00-12.00 цагт явагдана.

Линк: http://bimba3579.blogspot.com

Дүн 5 сарын 24-ны 14.00 цагт http://dornodedu.mn сайтад нийтлэнэ.
Даалгаврын тайлбар 12.30 цагт нийтлэнэ.

1. Дарааллыг аль хувилбар нь үргэлжлүүлэх вэ?



а. б. в. г. д.

А. Ухлаастай тэгш өнцөгт 90, ухлаастай гурвалжин 120 градусаар цагийн зүүний дагуу эргэж байна.

2. Асуултын тэмдгийн оронд аль цаг тохирох вэ?




а. 11:24 б. 09:44 в. 10:24 г. 11:42 д. 09:46

Г. Цаг 2-оор, минут 20-оор нэг нүд алгасан нэмэгдэж байна.

3. Асуултын тэмдгийн оронд аль нь тохирох вэ?




В. Хар дугуй 135 градусаар, цагаан дугуйнууд 90 градусаар, хэрчим 45 градусаар цагийн зүүний дагуу эргэнэ.

4. Хоосон зайнд аль дүрсийг байрлуулах вэ?




Д. Эсрэг сегментийн толин тусгал нь хар цагаан өнгө нь эсрэгээр солигдоно.

5. Асуултын тэмдгийн оронд аль нь тохирох вэ?




В. Урт шулуун 45 градусаар, богино шулуун болон тойргууд цагийн зүүний дагуу 90 градусаар эргэнэ.

6. Хоосон зайнд аль дүрсийг байрлуулах вэ?




В. Эхний хоёр мөр/ багана/-ийн эхний хоёр элементийн нийлбэрийг сүүлийн нүдэнд зуржээ. Ингэхдээ давхацсан зураасууд алга болно.

7.




Д. Тал дугуй дүрс болон жижиг дугуй дүрс өнгө болон байршлаа яг эсрэгээр нь өөрчилнө. Голын дүрс цагийн дагуу 90 градусаар эргэнэ.

8.

Бусдаасаа ялгаатай нь аль нь вэ?




Б. Бусад нь хос хосоороо ижил байна. Үүнд е ба ё, г ба д, а ба в хувилбарууд хоорондоо ижилхэн.

**9.** Өгсөн зургийг цаад талаас нь харахад аль нь вэ?




Д.

**10.** Дарааллыг аль хувилбар нь үргэлжлүүлэх вэ?




А. Жижиг цагаан баруун тийш 1, зүүн тийш 2, жижиг хар дугуй 1, баруун тийш 1, том цагаан дугуй зүүн тийш 1, баруун тийш 2 шилжиж байна. Тиймээс сүүлийн мөрөнд жижиг цагаан дугуй зүүн тийш 2, жижиг хар дугуй баруун тийш 1, том цагаан дугуй баруун тийш 2 нүд шилжинэ.

11. Дөрвөлжин цаасыг сумны дагуу нугалж, дүрс гарган хайчилсан. Цаасыг дэлгэхэд аль дүрс нь байх вэ?




В.

12. Бусдаасаа ялгаатай нь аль нь вэ?




В. Бусад хувилбар доорхи дүрсээс бүрдэнэ.



13. Бусдаасаа ялгаатай нь аль нь вэ?




Б. Бусад хувилбарт нь хар цэг ижил нэгэн байрлалд байна.

14. Асуултын тэмдгийн оронд аль нь тохирох вэ?




Г. Жижиг квадратуудын хүрээ нь давхардсан хэсгийг тодруулан зурвал “ХОСЛОЛ” гэсэн үг бүтээж байна.



15. Илүүц хувилбарыг олоорой.




В. Бусад хувилбар нь шооны дэлгээс болж чадахгүй.

16. Харь гарагийн хэлнээс орчуулсан үгс өгөгдөв.
**"аанлаан - шар малгай"**
**"зууртан - цэцгийн хүлэмж"**
**"танбуур - хүлэмжний навч"** гэсэн утгатай бол аль үг нь **"шар цэцэг"** гэсэн утгатай байж болох вэ?

а. аантан б. аанзуур
в. зууртаан г. аанзуурт

Б. Өгсөн нөхцлөөс аан-шар, лаан-малгай, зуур-цэцэг, тан-хүлэмж, буур-навч гэсэн утгатай байна. Иймд шар цэцэг нь аанзуур гэсэн үг.

17.

Дараалльг ямар амьтан үргэлжлүүлэх вэ?

**хонь, өрөвтас, галуу, жирх, имж ?**

а. нугас б. арслан в. ямаа г. үхэр д. луус

Д. Өгсөн үгсийн эхний үсгүүд ХӨГЖИЛ гэсэн үг бүтээж байна.

18.

Доорх нөхцөл үнэн бол дүгнэлтийг үнэлээрэй.

Нөхцөл 1: Хотод амьдардаг бүх сурагчид тэжээвэр амьтантай.

Нөхцөл 2: Халиунаа хотод амьдардаггүй.

Дүгнэлт: Халиунаад тэжээвэр амьтан байхгүй.

а. тийм б. үгүй в. магадгүй

В.

19.

Илүүц үгийг ол.

**А.Цахилдаг Б.Сурдаг В.Сонгодог**

**Г. Хийлдэг Д. Бичдэг**

А. Цахилдаг Бусад үгс нь үйл үг байна.

20.

Анаграмыг тайлж, илүүц хувилбарыг ол.

А.ҮРГДБЭ Б. НГҮЭ В. РАБ

Г. РВЭСИ Д. ОЧНО

А. Бүргэд бусад нь үнэг, бар, ирвэс,чоно нисдэггүй

21.

Хоосон нүдэнд тохирох үгийг ол.

| | | | |
|---|---|---|---|
| ЦАНА | ЧАРГА | МӨС | ЦАС |
| ХУРГА | ТУГАЛ | ХОНЬ | ХУН |
| ЖАЛГА | ХАД | МОД | ЖАД |
| ХИРС | БАР | ЗАРАА | |

А. ХАР Б. ХАГ В. ААШ Г. ХАШ Д. ЗАГ

А. Хар 4 дэх багана дахь үг 1-р баганын 1-р үсэг, 2-р баганын 2 дахь үсэг, 3-р баганын 3-дахь үсгүүдээр бүтнэ.

22.

Анаграмыг тайлж, илүүц хувилбарыг ол.

А. ДАМЖГУ
Б. ХНТОХО
В. ҮДРЭГҮ
Г. ЙХАРХАН
Д. ОХРОЛЛОО

Г. Хайрхан. Гудамж, хотхон, дүүрэг, хороолол хотын бүтэц нэрлэсэн.

23.

Мөр бүрээс ижил утга илэрхийлсэн үг орсон хувилбарыг ол.

I. зочин, ажилтан, хамтрал
II. нэгдэл, дэвшил, үйлчлүүлэгч

А. зочин, үйлчлүүлэгч
Б. ажилтан, дэвшил
В. хамтрал, нэгдэл
Г. зочин, нэгдэл
Д. хамтрал, дэвшил

В.

24.

"ховор" гэдэг үгийн ижил утгыг илэрхийлэх хувилбарыг ол.

А. элбэг Б. нүдний гэм В. баялаг
Г. хангалуун Д. арвин

Б.

25.

Этгээд болон хүндэтгэлийн үгсийг зөв харгалзуулсан хувилбарыг ол.

1. ажнай — а. мандал
2. гүнцэг — б. албан бичиг
3. халаглах — в. хоол
4. айлтгал — г. тэсэж ядах

А. 1в, 2г, 3а, 4б
Б. 1в, 2а, 3г, 4б
В. 1а, 2в, 3г, 4б
Г. 1а, 2б, 3в, 4г
Д. 1б, 2в, 3а, 4г

В.

26.

Зөв харгалзуулсан хувилбарыг ол.

1. зүсрэх — а. доргих
2. хашаа — б. хороо
3. хөдлөх — в. мяралзах
4. урсах — г. шиврэх

А. 1г, 2а, 3в, 4б
Б. 1г, 2в, 3а, 4б
В. 1а, 2в, 3г, 4б
Г. 1г, 2б, 3а, 4в
Д. 1в, 2а, 3б, 4г

Г.

27.

Анаграмыг тайлж, илүүц хувилбарыг тэмдэглэ. /1 оноо/

А. ДАРВА
Б. ДЛАСНА
В. ҮГҮШЭЭ
Г. ЭРИЭШ
Д. АУАУЛР

Д. ААРУУЛ /бусад нь АВДАР, САНДАЛ, ШҮҮГЭЭ, ШИРЭЭ гэсэн эд хогшил/

28.

Мөр бүрээс ижил санааг илэрхийлсэн үг орсон хувилбар аль нь вэ? /1 оноо/

**I. гачигдал, бартаа, гамшиг**
**II. илүүдэл, уралдаан, аюул**

А. гачигдал, илүүдэл
Б. бартаа, уралдаан
В. гамшиг, уралдаан
Г. гачигдал, аюул
Д. гамшиг, аюул

Д. /гамшиг, аюул ойролцоо утгатай./

29.

Асуултын тэмдгийн оронд тохирох үгийг ол. /1.5 оноо/

*нүүдэл, хөөлгөгч, чимхүүр, хэвлэл, ?*

А. мөчир Б. чичлүүр В. бүлтгэр
Г. шүүдэр Д. гавар

Г. шүүдэр. 1.5 оноо /Өгөгдсөн үгсийн эхний хоёр, мөн 4 дэх үсгүүдийг нийлүүлбэл ***нүд***, ***хөл***, ***чих***, ***хэл*** гэсэн эрхтний нэр үүсэж байна. Иймд шүүдэр--***шүд*** гэж үүснэ./

30.

Хоосон зайд аль хувилбар тохирох вэ?

**Зараа ба Зарга** /1 оноо/
**Нөхөр ба Нөмөр**
**Худам ба Хадам**
**Гараа ба Бараа**
**( . . . . . ) ба ( . . . . . )**

А. Хороо ба Бороо
Б. Бараа ба Барга
В. Суваг ба Сураг
Г. Булаг ба Балаг
Д. Судас ба Судар

Д. 1 оноо /Эхний үгсийн 4, 3, 2, 1 дэх үсгүүд өөрчлөгджээ. Иймд 5 дахь үсэг нь өөрчлөгдсөн хувилбар байх ёстой./

**31.**




Шоо 10 см ирмэгтэй. Оройноос эхлэн цэгүүдийг зурагт үзүүлсэн байдлаар 1 см-ийн зайтай байрлуулна. Нийт хэдэн цэг байрлуулсан бэ?

А. 128 Б. 116 В. 112 Г. 108 Д. 104

Ирмэг бүр дээр 11 цэг байна. Эдгээрээс 2 нь ирмэгийн төгсгөл буюу орой дээр, 9 нь ирмэг дээр байна. Шоо нь 12 ирмэг, 8 оройтой. Тиймээс зөвхөн ирмэг дээр 12 × 9 = 108 цэг, орой дээр 8 байна. Энэ нь нийт 108 + 8 = 116 цэг болно.

**32.**

Асуултын тэмдгийн оронд ямар тоо байх вэ?




А. 3 Б. 8 В. 12 Г. 16 Д. 24

Г. Огтлолцлолд байгаа тоо нь хоёр тойрог дотор байгаа 2 тоо хоёулаа тэгш /сондгой/ тоо байвал ялгавар /нийлбэр/ ба хэрэв тэгш, сондгой тоонууд бол үржвэрээр нь тодорхойлогдоно.

**33.**

| | | | | |
|---|---|---|---|---|
| 187 | 156 | 253 | 495 | 132 |

тоонуудын хэд нь 11-т хуваагдах вэ?

A. 1 B. 2 C. 3 D. 4 E. 5

187 = 11 × 17, 156 = 11 × 14 + 2, 253 = 11 × 23, 495 = 11 × 45, ба 132 = 11 × 12. Иймд өгөгдсөн тоонуудаас зөвхөн 156 нь 11-ийн үржвэр биш. Тиймээс тэдгээрийн дөрөв нь 11-ийн үржвэр болно.

34.



Зурагт тэгш хэмтэй байрлалтай 2 ба 5 гэсэн талтай квадратыг харуулж байна. Жижиг дөрвөлжингийн талбай болон харлуулсан хэсгийн талбайн харьцаа аль нь вэ?

А. 7:24 Б. 1:3 В. 8:25 Г. 8:21 Д. 2:5



Харлуулсан хэсгийн талбай нь том квадратын талбайн хагасаас жижиг квадратын талбайн хагасыг хассантай тэнцүү буюу $\frac{1}{2}\cdot(5^2)-\frac{1}{2}\cdot(2^2)=\frac{25}{2}-2=\frac{21}{2}$ болно.

Жижиг дөрвөлжингийн талбай болон харлуулсан хэсгийн талбайн харьцаа нь $4:\frac{21}{2}$ буюу 8:21 байна.

35.

123 − 456 + 789= Утгыг ол.

А. 456 Б. 556 В. 567 Г. 678 Д. 789

123 − 456 + 789 = 123 + 789 − 456 = 912 − 456 = 456.

36.

Батаа 240-ын хуваагч биш эерэг тоонуудыг жагсаан бичихэд 6 дахь тоо болон бичигдэх нь аль нь вэ?

А. 11 Б. 13 В. 14 Г. 15 Д. 17

240-ийн хуваагчдыг өсөх дараалаар бичвэл 1, 2, 3, 4, 5, 6, 8, 10, 12, 15, 16, 20, . . . , байна. Тиймээс 240-ийн хуваагч биш эерэг бүхэл тоонууд өсөх дараалаар 7, 9, 11, 13, 14, 17, . . . . байх нь тодорхой. Тиймээс Кай-н жагсаалтын зургаа дахь тоо нь 17 байна

**37.**




Зурагт 10 ба 14 гэсэн талтай тэгш өнцөгтийг хоёр өөр байрлалаар зэрэгцүүлэн зурав. O цэг тэгш өнцөгтийн хүндийн төв, M нь богино талын дундаж бол $OM$ хэрчмийн уртыг ол.

А. 12 Б. 15 В. 18 Г. 21 Д. 24




Өгсөн нөхцлүүдийг тооцон зургийг зурав. Зураг дээрээс ONM тэгш өнцөгт гурвалжны хувьд Пифогорын терем бичиж олох ёстой OM хэрчмийн уртыг олно. /15/

**38.**

12345 · 54321 -ийг 9-д хуваахад хэд үлдэх вэ?

А. 0 Б. 1 В. 2 Г. 3 Д. 4

12345 тооны цифрүүдийн нийлбэр 1+2+3+4+5=15 ба 15 нь 3-д хуваагдах учир 12345 тоо нь мөн 3-д хуваагдана. Нөгөө талаас 54321 тооны цифрүүдийн нийлбэр 15 учир 54321 тоо нь бас 3-д хуваагдана.
Иймд үржигдхүүн тус бүр 3-д хуваагдаж байгаа учир үржвэр нь 9-д хуваагдана. Иймд үлдэгдэл нь 0 байна.

**39.**

Асуултын тэмдгийн оронд ямар тоо байх вэ?

3 ; 4 ; 6 ; 9 ; 13 ; 18 ; ?

А. 21 Б. 22 В. 23 Г. 24 Д.30

Гишүүд 1,2,3,4,5,6-аар нэмэгдэнэ. 18+6=24 байна.

**40.**

Асуултын тэмдгийн оронд тохирох тоог олоорой.

6 ; 1 ; 7 ; 12 ; 3 ; 15 ; 2 ; 10 ; ?

А. 12 Б. 15 В. 18 Г. 20 Д. 21

Эхний 2 тооны нийлбэрээр 3 дахь тоо гарч байна. Ийм байдлаар 3:3-аар нь бүлэглэвэл 12+3=15 ; 2+10=12

41.




Дээрх тоонуудаа $\boxed{ab}$ тоо илүүц байна.

13 тоог 4 ба 16, 5 ба 20, 7 ба 28, 8 ба 32, 9 ба 36, 14 ба 56 гэж / эхний тоог 4-ээр үржихэд 2 дахь тоо гарч байна/ гэж авахад 18 сондгойрон үлдэж байна.

42.

| | |
|---|---|
| 12348 | 32418 |
| 14789 | 84129 |
| 24567 | 57624 |
| 12356 | ? |

Асуултын тэмдгийн оронд $\boxed{abcde}$ тоо байна.

А. Эхний багана дахь тооны цифрүүдийн нийлбэр нь 2 дахь баганын тоон сүүлийн 2 оронтой тэнцэнэ. Түүний квадрат нь урдах 3 оронтой тоог илэрхийлнэ.

1+2+3+4+8=18 18^2=324

1+4+7+8+9=29 29^2=841

2+4+5+6+7=24 24^2=576

1+2+3+5+6=17 17^2=289 буюу **28917** тоо байна.

43.



Зурагт гурван төрлийн квадратуудад хуваагдсан том квадрат харагдаж байна. Том квадратын талбайн $\boxed{ab}$ хувь нь харлуулсан байна.




Бутархай утганаас зайлсхийхийн тулд нэг том квадрат ба 2 жижиг квадратын урт нь 3 дундын квадратын урттай тэнцүү байгааг зургаас харж болно.
Өөрөөр хэлбэл $2x + z = 3y; x, y, z \in N$ тэгшитгэлийн хамгийн утгатай шийдүүд нь $\{3,4,6\}$ байна гэдгийг хялбархан харж болно. Мөн эндээс хамгийн том буюу эдгээр 3 төрлийн квадратуудыг багтаасан квадратын тал нь 20 болох ба түүний талбай 400 байна.
Зураг дээр харлуулсан жижиг квадрат 4, дундын квадрат 8, том квадрат 2 ширхэг байгааг харж байна. Эдгээрийн талбай нь $4(3\cdot 3) + 8\cdot(4\cdot 4) + 2\cdot(6\cdot 6) = 36 + 128 + 72 = 236$ болно. Харлуулсан хэсгийн талбайн хувийг олохдоо $\frac{236}{400} = \frac{59}{100}$ буюу 59% нь болно.

44.




Асуултын тэмдгийн оронд $\boxed{ab}$ тоо байна.

Гурвалжны суурийн орой дээр байгаа тоонуудын квадратын нийлбэр дээр оройн тоог нэмэхэд голын тоо гарна. $6^2 + 5^2 + 12 = 36 + 25 + 12 = 73$;
$2^2 + 3^2 + 17 = 4 + 9 + 17 = 30$;
$4^2 + 7^2 + 23 = 16 + 49 + 23 = 88$

45.




Зурагт $p$, $q$ тал бүхий хоёр тэгш өнцөгтийг хөндлөн давхардсан байдалтай өгчээ. Давхардсан хэсгийн талбай нь нийт талбайн дөрөвний нэг болно. $p$:$q$ харьцаа $\boxed{a: b}$ байна.

Давхардсан /хар/хэсгийн талбай нь $q^2$ ба тэгш өнцөгтийн талбай нь $pq$ байна. Нийт талбай нь $2pq - q^2$ байна. Өгсөн нөхцөл ёсоор $q^2 = \frac{1}{4}(2pq - q^2)$ болох бөгөөд $4q^2 = 2pq - q^2$ ; $5q^2 = 2pq$ буюу $5q = 2p$ болно. Эндээс $\frac{p}{q} = \frac{5}{2}$ буюу $p: q = 5: 2$ байна.